



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 1/01

Мандалговь

Цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, 57.3, 57.17 дахь хэсэг, Засгийн газрын "Журам батлах тухай" 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 2, 5 дугаар хавсралт, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2023 оны 241 дүгээр тогтоолын 3, 10 дугаар хавсралт, Сангийн сайдын 2023 оны 32 дугаар тушаалаар батлагдсан "Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журам"-ын 3.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус хэлтсийн бүтцийн нэгжийн болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосугай.

2.Албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож олгохыг нягтлан бодогч (Н.Долгорсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хуулийн тасгийн дарга (Ш.Мөнгөнцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



М.ТУЯАЦЭЦЭГ

487408016



